

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тохижилтын
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/71/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
(Дорноговь аймгийн Сайншанд сум)
2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: .70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
Аудитын менежерийн үүргийг
түр орлон гүйцэтгэгч Э.Энхцэцэг
Утас: 70523020 Цахим хаяг: enkhtsetseg@audit.gov.mn
Аудитор: Б.Отгон-Өлзий
Утас: 99844655 Цахим хаяг: shilenbalanceaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	10
2.12.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.13.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.14.	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан	11

1. Аудитын гэрчилгээ

 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Вэб сайт: dornogovi@audit.gov.mn	ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН ЗҮҮНБАЯН ТОХИЖИЛТЫН АЛБАНЫ ДАРГА З.АМАРСАЙХАН ТАНАА
<u>2020.02.28</u> № <u>1-6/166</u> танай _____ -ны № _____ -т	
Аудитын гэрчилгээ	
<p>Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тохижилтын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Зөрчилгүй санал дүгнэлт	
<p>Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тохижилтын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тохижилтын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тохижилтын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг З.Амарсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тохижилтын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тохижилтын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 сарын 25-ны өдрөөс 2020 оны 01 сарын 26-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 01 сарын 26-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Шилэн баланс Аудит ХХК-ний аудитор Б.Отгон-Өлзий хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян Тохижилтын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын

газарт 2020 оны 01 сарын 22 өдөр-ны өдрийн 04 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тохижилтын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Сайншанд сумын Зүүнбаян Тохижилтын эрхэм зорилго нь Орон нутагт хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, цэвэр, цэмцгэр ногоон байгууламж бүхий баг болгон хөгжүүлэхэд зорилго оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян Тохижилтын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хот тохижилт хог зөөвөр

Байгууллагын төсвийн захирагч нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тохижилтын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тохижилтын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тохижилт нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ний "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тохижилтын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн, гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тохижилтын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд 42 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож эрсдлийн түвшинг бага гэж үнэлэн 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 179,850.7 мянган төгрөгөөс тооцон 3,597.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тохижилтын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 68,854.9 мянган төгрөгөөр буюу 10.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	1,857.3	781.0	-1,076.3
Урьдчилгаа			
Бараа материал	6,577.3	6,642.0	64.7
Үндсэн хөрөнгө	720,506.7	722,572.7	2,066.0
Нийт хөрөнгө	632,010.8	563,155.9	-68,854.9
Өр төлбөр	57.0	115.8	-58.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	631,953.8	563,040.1	-68,913.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	632,010.8	563,155.9	-68,854.9

Авлага дансны үлдэгдэл 1,076.3 мянган төгрөгөөр буурсан нь хувь хүнээс авах авлагыг барагдуулснаас шалтгаалжээ. Он удаан жил болсон насжилт өндөртэй авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 64.7 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал үлдэгдэл 18.4 мянган төгрөгөөр, сэлбэг хэрэгслийн үлдэгдэл 907.0 мянган төгрөгөөр өсч, аж ахуйн материалын үлдэгдэл 506.0 мянган төгрөгөөр түлш шатах тослох материалын үлдэгдэл 354.6 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,066.0 мянган төгрөгөөр өссөн нь бусад хөрөнгийн үлдэгдэл 1,556.0 мянган төгрөгөөр, тоног төхөөрөмжийн үлдэгдэл 510.0 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Төсвийн хөрөнгөөр 510.0 мянган төгрөгийн ширээ сандал, хандиваар 1,556.0 мянган төгрөгийн дэгээтэй бункер, хогийн сав, нийт 2,066.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн.

Өр төлбөр дансны үлдэгдэл 58.5 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагад төлөх өглөг 13.6 мянган төгрөгөөр буурч, хувь хүнд өгөх өглөг 52.4 мянган төгрөгөөр, татварын өглөг 20.0 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 563,040.1 мянган төгрөг болж 68,913.7 мянган төгрөгөөр буурсан байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тохижилт тайлант онд орлогын төлөвлөгөөгүй ажилласан байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны хүрээнд		2,086.0	2.086.0	
Нийт дүн		2,086.0	2.086.0	

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд 2,086.0 мянган төгрөгийн орлого оруулсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 107,338.3 мянган төгрөгийн төсөв батлагдаж, урсгал зардалд, зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 107,338.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй харьцуулвал

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	74,619.6	74,619.6	-	100.0
2	НДШ-ийн зардал	10,752.8	10,752.8	-	100.0
3	Гэрэл, цахилгаан	560.0	598.7	38.7	106.9
4	Цэвэр, бохир ус	1,955.6	1,916.9	(38.7)	98.0
5	Бичиг хэрэг	500.0	500.0	-	100.0
6	Тээвэр, шатахуун	5,100.0	5,100.0	-	100.0
7	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	164.0	164.0	-	100.0
8	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	1,500.0	1,500.0	-	100.0
9	Урсгал засвар	800.0	800.0	-	100.0
10	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	11,386.3		(11,386.3)	-
	Нийт зардлын дүн	107,338.3	95,952.0	-11,386.3	89.4

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 95,952.0 мянган төгрөг буюу 89.4 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 11,386.3 мянган төгрөгийн зардлыг гаргаагүйтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,086.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс багаж хэрэгсэл худалдан авахад 1,180.0 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэл худалдан авахад 406.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 500.0 мянган төгрөг, нийт 2,086.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 0 эрсдэл тодорхойлж нийт 2 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тохижилт Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 123 мэдээллийг хугацаанд нь, 25 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,857.3 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоосноос 1,033.0 мянган төгрөгийг барагдуулсан байна.

Актын төлбөрийн барагдуулалт 44.4 хувийн биелэлттэй байна. Ажиллагсдаас авах 781.0 мянган төгрөгийг хуулийн байгууллагаар шийдүүлэхээр өгсөн байна. 43.3 мянган төгрөгийг холбогдох эздээс суутган авсан төсөвт төвлөрүүлэхээр хүлээгдэж байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тохижилт 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тохижилтын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>8,434,605.09</u>	<u>7,422,980.00</u>
33	АВЛАГА	1,857,278.62	781,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	781,000.00	781,000.00
335	Бусад авлага	1,076,278.62	00.00
3351	Байгууллагаас авах авлага	1,076,278.62	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6,577,326.47	6,641,980.00
354	Хангамжийн материал	6,577,326.47	6,641,980.00
35410	Бичиг хэргийн материал	448,600.00	466,980.00
35420	Аж ахуйн материал	5,021,100.00	4,515,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	753,000.00	1,660,000.00
35440	Түлш, шатах тослох материал	354,626.47	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>623,576,233.74</u>	<u>555,732,892.35</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	623,576,233.74	555,732,892.35
392	Биет хөрөнгө	112,748,233.74	44,904,892.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	65,112,931.04	65,112,931.04
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-54,523,045.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	57,695,000.00	57,695,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-27,695,000.00	-32,195,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	38,742,333.00	38,742,333.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-34,996,785.36	-36,301,245.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,053,300.00	3,563,300.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1,342,753.44	-1,866,570.04
39214	Бусад үндсэн хөрөнгө	44,671,112.24	46,227,112.24
39215	Хуримтлагдсан элэгдэл	-32,495,903.74	-41,553,923.01
39217	Ном	4,000.00	4,000.00
393	Биет бус хөрөнгө	510,828,000.00	510,828,000.00
39301	Програм хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-400,000.00	-400,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	510,828,000.00	510,828,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>632,010,838.83</u>	<u>563,155,872.35</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>56,991.00</u>	<u>115,785.36</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	56,991.00	115,785.36
413	Өглөг	56,991.00	115,785.36
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	19,999.54
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	64.00	00.20
4136	Бусад өглөг	56,927.00	95,785.62
41361	Байгууллагад төлөх өглөг	56,900.00	43,315.62

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тохижилтын 2019 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41362	Хувь хүмүүст төлөх өглөг	27.00	52,470.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>631,953,847.83</u>	<u>563,040,086.99</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	631,953,847.83	563,040,086.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	574,314,842.00	574,314,842.00
51101	Өмч: - төрийн	510,828,000.00	510,828,000.00
51102	- хувийн	63,486,842.00	63,486,842.00
512	Хуримтлагдсан үр дүн	-2,959,705.01	-71,873,465.85
51210	Өмнөх үеийн үр дүн	-2,959,705.01	-2,959,705.01
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-68,913,760.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	60,598,710.84	60,598,710.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>632,010,838.83</u>	<u>563,155,872.35</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	128,473,266.56	110,980,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,118,166.56	1,556,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	25,118,166.56	1,556,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,118,166.56	1,556,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	25,118,166.56	1,556,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	103,355,100.00	109,424,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	101,265,600.00	107,338,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	101,265,600.00	107,338,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,089,500.00	2,086,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,089,500.00	2,086,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	111,135,416.22	179,894,060.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	109,205,416.22	179,894,060.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	109,205,416.22	179,894,060.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	62,782,463.03	72,515,086.39
210101	Үндсэн цалин	58,305,234.67	64,270,042.99
210105	Гэрээт ажлын хөлс	4,477,228.36	8,245,043.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,669,285.93	14,193,132.09
210201	Тэтгэврийн даатгал	12,358,024.29	14,193,132.09
210202	Тэтгэмжийн даатгал	329,400.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	257,061.64	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	57,000.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	667,800.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,733,364.02	2,850,341.29
210301	Гэрэл, цахилгаан	3,076,279.00	803,674.09
210302	Түлш, халаалт	00.00	00.00
210303	Цэвэр, бохир ус	2,657,085.02	2,046,667.20
2104	Хангамж, бараа материалын зардал	8,915,067.53	9,881,665.68
210401	Бичиг хэрэг	510,480.00	659,120.00
210402	Тээвэр, шатахуун	5,789,933.53	5,305,026.47
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	151,097.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,463,557.00	3,917,519.21
2105	Нормативт зардал	600,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,233,200.00	1,478,400.00
210604	Урсгал засвар	1,233,200.00	1,478,400.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,977,567.00	9,066,094.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,977,567.00	8,992,094.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	74,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,294,468.71	69,909,341.39
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,294,468.71	69,909,341.39

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тохижилтын 2019 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,930,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,930,000.00	00.00
222001	Тоног төхөөрөмж	1,930,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>17,337,850.34</u>	<u>-68,913,760.84</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	40,927,600.09	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	19,013,333.24	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	21,914,266.85	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-40,927,600.09	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-23,589,749.75</u>	<u>-68,913,760.84</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	103,355,100.00	109,424,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	103,355,100.00	109,424,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	101,265,600.00	107,338,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	101,265,600.00	107,338,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,089,500.00	2,086,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,089,500.00	2,086,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	101,765,600.00	108,914,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	101,765,600.00	108,914,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	101,765,600.00	108,914,300.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	67,376,900.00	74,619,600.00
210101	Үндсэн цалин	55,730,748.00	62,619,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	11,646,152.00	12,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,322,800.00	10,752,800.00
210201	Тэтгэврийн даатгал	7,913,538.36	6,529,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	603,900.00	1,204,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	476,561.64	822,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	112,000.00	254,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,216,800.00	1,941,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,615,600.00	2,515,600.00
210301	Гэрэл, цахилгаан	524,046.00	598,677.00
210302	Түлш, халаалт	00.00	00.00
210303	Цэвэр, бохир ус	4,091,554.00	1,916,923.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,414,000.00	7,264,000.00
210401	Бичиг хэрэг	871,000.00	500,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,729,000.00	5,100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	164,000.00	164,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,650,000.00	1,500,000.00
2105	Нормативт зардал	00.00	406,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	406,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,450,000.00	1,980,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,150,000.00	1,180,000.00
210604	Урсгал засвар	1,300,000.00	800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,586,300.00	11,376,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,586,300.00	11,376,300.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,589,500.00	510,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,589,500.00	510,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,589,500.00	510,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,589,500.00	510,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,589,500.00	510,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,589,500.00	-510,000.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	63,486,842.00	12,302,605.66	20,630,044.74	96,419,492.40
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	63,486,842.00	12,302,605.66	20,630,044.74	96,419,492.40
C07	Тайлант үеийн үр дүн	510,828,000.00	00.00	-23,589,749.75	487,238,250.25
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	574,314,842.00	60,598,710.84	-2,959,705.01	631,953,847.83
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	574,314,842.00	60,598,710.84	-2,959,705.01	631,953,847.83
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	574,314,842.00	60,598,710.84	-2,959,705.01	631,953,847.83
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-68,913,760.84	-68,913,760.84
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	574,314,842.00	60,598,710.84	-71,873,465.85	563,040,086.99

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл					
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	107,338,300.00	95,952,000.00	-11,386,300.00	89.4	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	107,338,300.00	95,952,000.00	-11,386,300.00	89.4	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	107,338,300.00	95,952,000.00	-11,386,300.00	89.4	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	74,619,600.00	74,619,600.00	00.00	100.0	
210101	Үндсэн цалин	62,619,600.00	62,619,600.00	00.00	100.0	
210105	Гэрээт ажлын хөлс	12,000,000.00	12,000,000.00	00.00	100.0	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,752,800.00	10,752,800.00	00.00	100.0	
210201	Тэтгэврийн даатгал	6,529,900.00	6,529,900.00	00.00	100.0	
210202	Тэтгэмжийн даатгал	1,204,900.00	1,204,900.00	00.00	100.0	
210203	ҮОМШӨ-ний даатгал	822,000.00	822,000.00	00.00	100.0	
210204	Ажилгүйдлийн даатгал	254,400.00	254,400.00	00.00	100.0	
210205	Эрүүл мэндийн даатгал	1,941,600.00	1,941,600.00	00.00	100.0	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,515,600.00	2,515,600.00	00.00	100.0	
210301	Гэрэл, цахилгаан	560,000.00	598,677.00	38,677.00	106.9	
210303	Цэвэр, бохир ус	1,955,600.00	1,916,923.00	-38,677.00	98.0	
2104	Хангамж, бараа материалын зардал	7,264,000.00	7,264,000.00	00.00	100.0	
210401	Бичиг хэрэг	500,000.00	500,000.00	00.00	100.0	
210402	Тээвэр, шатахуун	5,100,000.00	5,100,000.00	00.00	100.0	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	164,000.00	164,000.00	00.00	100.0	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,500,000.00	00.00	100.0	
210604	Урсгал засвар	800,000.00	800,000.00	00.00	100.0	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,386,300.00	00.00	-11,386,300.00	100.0	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,386,300.00	00.00	-11,386,300.00	00.0	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	107,338,300.00	107,338,300.00	00.00	00.0	
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	107,338,300.00	107,338,300.00	00.00	100.0	
131001	Улсын төсвөөс санхүүжих	107,338,300.00	107,338,300.00	00.00	100.0	